



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/381

Хэрлэн сум

Сургалт зохион байгуулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 04, 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг ерөнхий чиг баримжаа олгох чадавхжуулах сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 22-ний өдөр Чингис хотод зохион байгуулж, 8,000,000 (найман сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Сургалт зохион байгуулах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Сургалтад шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Үнэнбат)-д, тус арга хэмжээнд хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж удирдамжийн дагуу зохион байгуулж тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантөмөр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

